



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2019 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 1/52

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Ховд аймгийн Булган сумын агропаркийн тоног төхөөрөмж худалдан авах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

- Дарга: Ш.Нохойжав - Орон нутгийн өмчийн газрын дарга
- Гишүүд: Д.Бөхболд - Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн
- Б.Батзол - Төрийн бус байгууллагын төлөөлөл
- Ц.Өлзийбат - Иргэний төлөөлөл
- Нарийн бичгийн дарга: Х.Дэмид - Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /Ш.Нохойжав/-нд үүрэг болгосугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Х.Дэмид/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Д.ЭНХБОЛД

